

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ТАЙЛАН

2024 оны 11-р сарын 27

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.						
	2.1.1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	"Хавдрын эсрэг" арга хэмжээ	2020-2024	700.0 Улсын төсөв (ЭМДС)	Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хүрэх түвшин 60 хувьд хүргэнэ.	Хавдрын эсрэг арга хэмжээний тайланг хавсралтаар тайлагнав. Хавсралт 1. Хавдрын эсрэг арга хэмжээний тайлан

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2023 он (сая төгрөг), Эх үүсвэр	2023 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр
	2.1.6. “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ	4.Орон нутгийн Эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ	2021-2024	500.0 Улсын төсөв	Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллага, 31 аймгийн А зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтэрсэн байна.	Хорт хавдрын тусламж үйлчилгээ болон сургалтад телемедицин ашиглах зорилгоор “Алсын зайн оношилгоо, тусламж үйлчилгээний журам” боловсруулан баталсан. Уг журмын дагуу долоо хоног бүрийн Даваа, Лхагва, гарагт аймгуудтай холбогдож, хими эмчилгээ, хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чиглэлээр эмч нарын зөвлөгөөн зохион байгуулж байна. Сард нэг удаа хөнгөвчлөх тусламж үйлчилгээний цахим сургалт зохион байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар 21 аймаг, 9 дүүргийн хавдар бүртгэгч нарыг хамруулсан цахим сургалтыг нийт 4 удаа зохион байгуулсан бөгөөд сургалтын хүрээнд хорт хавдрын өвчлөл, нас баралт, хяналтын сарын мэдээ, мэдээний сангийн алдаа зөрчлийг танилцуулах, зөрчлийг арилгах, хоорондоо сайн туршлага солилцох үйл ажиллагаа хийгдлээ. Хавдар бүртгэгчийн баримжаа олгох 14-21 хоногийн ажлын байрны дадлага сургалтанд Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Дорнод аймгийн, Баянгол дүүргийн нийт 6 хавдар бүртгэгчийг хамруулсан.
		Үзлэгийн цаг товлох үйлчилгээг нэвтрүүлнэ				Үзлэгийн цагийг цахимаар болон утсаар товлон үйлчилж байна. Үзлэгийн цагийг онлайнаар /E-Mongolia, call center/ 1800-01-09 болон ХСҮТ-ийн 72724000 утсаар захиалга авч, давтан үзлэгийн цагийг эмч олгож байна. Урьдчилан цаг захиалга -42112, онлайнаар цаг захиалга нь цаг захиалан үйлчлүүлсэний үр дүнд орон нутгийн иргэд хяналтын үзлэгийг товлосон цагтаа хүлээгдэлгүй үзүүлэх боломж бүрдсэн. <ul style="list-style-type: none"> • call center -795 • emongolia- 1065 • onlain -452 • цахим бүртгэл 81985 Нийт 84297 хүнд товлолт үйлчилгээ хүргэсэн байна.

<p>2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.</p>	<p>3.Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ</p>	<p>2021-2024</p>	<p>1,000.0 Улсын төсөв</p>	<p>100 хүртэлх эмч, мэргэжилтэн ажиллан суралцсан байна.</p>	<p>Ажиллан суралцах журмын хүрээнд ХСҮТ-ийн эмч мэргэжилтнүүдээс 2024 онд төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хавдрын туяа эмчилгээ судлал төрөлжсөн мэргэшлээр 3 эмч, мэдрэлийн мэс засал судлалаар 1 эмч, хавдрын хими эмчилгээ судлалаар 2 эмч, эрүүл мэндийн чанар эрсдэлийн удирдлагаар 1 эмч, уушиг голтын хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтыг 1 эмч, элэг цөсний хавдрын мэс заслаар 2 эмч, нийт 10 эмч хавдрын сувилахуй судлалаар 1 сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлалаар 3 сувилагч тус тус суралцаж амжилттай төгссөн.</p> <p>Ажлын байранд чадавхижуулах сургалт:</p> <ol style="list-style-type: none"> 1. ХСҮТ-ийн ЭМЗТ-ийн эмч нарын баг 2024.05.13-06.25 ны хугацаанд Сүхбаатар, Увс, Өмнөговь аймгийн НЭ-т ажиллаж, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт “Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал” сэдэвт ажлын байрны 4 багц цагийн сургалтад 60 эмнэлгийн мэргэжилтэн, 2. Өмнөговь аймгийн БОЭТ, Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн эмгэг судлаач эмч, техникч нарт 2024.08.25-наас 2024.09.08 хугацаанд 30 эмнэлгийн мэргэжилтэн, 3. “Хавдрын эсрэг үндэсний аян-2024” хүрээнд 9 дүгээр сарын 2024.09.15-20-ны хооронд Баян-Өлгий, Баянхонгор аймгийн өрх, сумын эмч нарт “Зонхилон тохиолдох хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээ” сэдэвт 1 багц цагийн сургалтад 150 эмнэлгийн мэргэжилтэн <p>Хавдрын хими эмчилгээний найруулга зүй” сургалтын хөтөлбөрийг батлуулан сургалтын эрх авч, Ажиллан сургах хөтөлбөрийн дагуу 2.5 багц цагийн сургалтыг ЭМХТ-тэй хамтран зохион байгуулж, УГТЭ, УХТЭ, УНТЭ, Говь- Алтай, Архангай, Өмнөговь,Увс, Сэлэнгэ, Дархан-Уул, Дундговь, Орхон аймгийн болон Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Багануур дүүргийн нийт 24 эмч, эм найруулагч нарыг сургалтанд хамруулсан.</p> <p>2023-2024 оны хичээлийн жилд ХСҮТ-ийн эмч мэргэжилтнүүдээс толгой хүзүүний мэс засал судлал төрөлжсөн мэргэшлээр 1 эмч, хавдрын хими эмчилгээ судлалаар 1 эмч, эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 эмч, ходоод нарийн гэдэсний хавдрын мэс засал судлал мэргэшлээр 2 эмч, хөхний хавдрын мэс заслаар 2 эмч нийт 10 эмч, хавдрын сувилахуй судлалаар 6 сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлалаар 9 сувилагч</p>
---	---	------------------	--------------------------------	--	--

						ажиллан суралцах хөтөлбөрт хамрагдан суралцаж байна. Мөн энэхүү хөтөлбөрийн дагуу УГТЭ, УНТЭ-ээс тус бүр 2 эмч Толгой хүзүүний хавдрын мэс заслын төрөлжсөн мэргэшлийн сургалтад хамрагдаж төгссөн.
		4.Эрүүл мэндийн байгууллага цалин, урамшууллыг ёс зүй, харилцаа хандлагатай уялдуулж олгодог болсон байна.	2022-2024			“ХСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн цогц чадамжид суурилсан үнэлгээ хийх журам”-ын дагуу 2023 ажилчдад чадамжийн үнэлгээг хийж, ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны А/35 дугаар тушаалаар цалингийн шинэ системд шилжүүлэн үндсэн цалинг дундажаар 49% нэмсэн. Цогц чадамжид суурилсан үнэлгээнд ёс зүй, харилцаа хандлагын үнэлгээг 1 шалгуур үзүүлэлт болгон оруулж тооцсон. 1. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2021 оны тушаалаар “Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох тухай” журмыг шинэчлэн баталсан. Сар бүр нийт ажилтнуудын ёс зүй, харилцаа хандлагын байдалд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос үнэлгээ өгч ажилласан. 2024 оны 1 дүгээр улиралд 446, 2 дугаар улиралд 419, 3-р улиралд 416 ажилтанд тус тус урамшуулал олгосон байна. Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулсны дагуу ажил дүгнэсэн албан тушаалтнаар оноог тавиулан гарын үсэг зуруулан баталгаажуулж, ажлыг нь дүгнэсэн оноог ажилтан тус бүрт танилцуулан ажиллаж байна.
2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	5.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ	2021-2023	933.0 Улсын төсөв	Хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжилт 70 хувь байна.	ХСҮТ-ийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд 20 ажил төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна ба тэдгээрээс эхний хагас жилийн байдлаар дараах ажлыг хэрэгжүүлэн ажилласан. ● Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Засгийн газрын тогтоолыг үндэслэн 2024 онд зарим ажилтны цалинг 1 удаа нэмсэн. ● Томуугийн улирал буюу 2024-01-04-с 2024.03.30 болон 2024.11.01-с эхлэн ажилтнуудын дархлааг дэмжих витаминжуулах зорилгоор өглөө бүр чацаргана болон бусад жимсний шүүс, аарц зэргийг бүх ажилтнууддаа өгч ажилласан. ● 2024 оны 04-р сард “Үйлчлэгч нартаа баярлалаа” талархлын өдрийн хүрээнд төвд ажиллаж байгаа үйлчлэгч нартаа талархалаа илэрхийлэн, ажлын урам зориг өгөх зорилгоор баярын өдөр болгон зохион байгуулсан. ● 2024 оны 3-р сараас эхлэн “Эрүүл биеэрээ гоёцгооё” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөтөлбөрт 30 ажилтан хамрагдсан.	

					<ul style="list-style-type: none">• 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийн баярыг тохиолдуулан хүүхэдтэй ажилтнуудад Үндэсний соёл амралтын хүрээлэнд тоглох 4 тоглоомын эрхийн бичиг хуваарилсан.• ХСҮТ-ийн Хүүхэд хамгаалах бодлогын хүрээнд эцэг, эхийн зөвлөлийг шинээр байгуулсан ба 2024 оны 05-р сард нийт эмч, ажилтнуудын хүүхдийн (530 хүүхэд) судалгааг шинэчлэн гаргасан.• Тус төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 5-р бүлгийн 6 дахь заалт, төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид хүүхэд нь элсэн орж суралцаж байгаа нийтдээ 29 ажилтанд 2023-2024, 2024-2025 оны хичээлийн жилийн хугацаанд өдөр бүр ажлын цагаас 30 минутын хугацаагаар богиносгон хөнгөлөлт үзүүлэн цалинтай чөлөө олгож ажилласан.• Магистрантурт суралцаж төгссөн 3-н эмч, ажилтны сургалтын төлбөр 2.3 сая төгрөгийг байгууллагаас олгон сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн.• Хөдөлмөрийн дотоод журмын дагуу аав, ээж, нөхөр, хүү нь нас барсан 15 ажилтанд 250 000 төгрөгийн 1 удаагийн тэтгэмж олгосон ба үүнд нийтдээ 3.7 сая төгрөг зарцуулан ажилласан.• Давагдашгүй хүчин зүйл буюу гэр нь шатсан 1 ажилтан буцалтгүй тусламж болгон 500 000 төгрөгөөр тусалсан.• Төвийн хэмжээнд ахмадын бүртгэлтэй 201 ахмад настан бүртгэгдсэн ба тэдгээрээс нас барсан 1 ахмад настны гэр бүлд эмэгнэл илэрхийлж 1 удаагийн тэтгэмж олгосон.• Улсдаа болон эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй эмч ажилтнуудыг салбарын болон төрийн дээд одон медаль нэр дэвшүүлэн тодорхойлж 2024 онд Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр 10 ажилтан, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр 7 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 15 ажилтан, “Алтан гадас” одонгоор 7 ажилтан, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2 ажилтан тус тус шагнагдсан байна.• МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу төвийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад хууль, тогтоомжийн дагуу хөнгөлөлт ХХОАТ-ын 10 хувийг, НД болно ЭМ даатгалын тодорхой хувиар чөлөөлсөн, ээлжийн амралтанд нэмж 5 өдөр олгох г.м)-ийг эдлүүлэн ажилласан.
--	--	--	--	--	---

					<ul style="list-style-type: none"> • Банкаас хэрэглээний зээл авах, хүүхдээ гадаадад сургах, виз мэдүүлэх г.м шалтгаануудаар эмч, ажилтнуудад давхардсан тоогоор 350 гаран ажилтанд тодорхойлолт олгосон. <p>Хавсралт-2. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн тайлан</p>	
		6.Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ	2021-2024	500.0 Гадаадын зээл, тусламж	<p>Сургалтыг удирдах сувилагч-сургагч багш 50-аас доошгүй бэлтгэгдсэн байна.</p> <p>Сургалтын 2-3 хөтөлбөр шинэчлэгдсэн байна.</p>	<p>2021-2024 онд “Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ЭМЯ, ЭМХТ болон Жайка ОУБ-тай хамтран ажиллаж байна. 2021-2022 онд нийт 10 сувилагч сувилахуйн эмнэлзүйн сургагч багшаар суралцсан. 2022-2024 онд төслийн хүрээнд сувилахуйн эмнэлзүйн сургагч багшаар нийт-7, арга зүйч Н.Наранчимэг, арга зүйч Ч.Лазат, Хагалгаа мэдээгүйжүүлгийн тасгийн ахлах сувилагч Б.Оюумаа, Эрчимт эмчилгээний тасгийн ахлах сувилагч Б.Оюун-Эрдэнэ, Толгой хүзүүний мэс заслын ахлах сувилагч Г.Уранцэцэг, Ерөнхий мэс заслын тасгийн ахлах сувилагч Б.Бадамдолгор, Туяа эмчилгээний тасгийн ахлах сувилагч Г.Жамьянтүдэв нар суралцан төгссөн.</p> <p>Мөн Сувилахуйн албаны дарга Ю.Оюунзул, ХМНТасгийн ахлах сувилагч Б.Оюумаа, ЭЦНБ тасгийн ахлах сувилагч С.Өсөхбаяр нар сувилахуйн чиглүүлэгч багшаар нийт 3 хүн тус тус суралцаж төгссөн байна.</p> <p>-2024 оны байдлаар төслийн хүрээнд нийт 20 сувилагч сургалтанд хамрагдсан байна.</p> <p>ХСҮТ нь Хавдрын сувилахуй, Хөнгөвчлөх сувилахуйн мэрэгшүүлэх курсыг бие даан хэрэгжүүлдэг ба жилд 35-40 сувилагчдын төгсгөн гаргаж байна. Эдгээр сургалтын хөтөлбөрүүдэд дахин сайжруулалтыг хийж байна.</p>

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

<p>4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.</p>	<p>3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана (Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм)</p>	<p>2021-2024 -</p>	<p>Сургалт, сурталчилгааг явуулснаар үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.</p>	<p>Төвийн хэмжээнд ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах болон ажилтнуудыг соён гэгээрүүлэн чиглэлээр төлөвлөгөө үнэтгэргэн хэрэгжүүлэн ажилласан.</p> <p>Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p> <ul style="list-style-type: none"> – Тус төвийн нийт эмч, ажилтнуудын мэдлэгийг үнэлэх сорил авахаар төлөвлөсний дагуу ажилтнууддаа 1 сарын өмнөөс буюу 2024 оны 04 дүгээр сард мэдээлэл хийж, уншиж судлах материалын жагсаалт (Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль)-ыг фэйсбүүк групп, тасаг, албаны дотоод групп, e-health программаар дамжуулан мэдээлсэн. Түүний дагуу 2024 оны 05 дугаар сард 3-н групп болгон нийт ажилтнуудаасаа мэдлэг сорих сорилын тест авсан. Сорилыг google form болон цаасаар гэсэн 2 төрлөөр авсан. – 2024 оны 01-р сарын 12-ны өдөр “Хандлага, харилцааны ур чадвар” сэдвээр сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд төвийн ёс зүйн салбар хорооноос сургалт хийсэн ба нийтдээ 80 ажилтан хамрагдсан. – Төвийн эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулан “Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй”, “Ажилтан бүх хөтөч” сэдвээр сургалтыг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Нийт 29 ажилтан хамрагдсан. – Монголын уламжлалт анагаах ухаанд мөрдөж ирсэн мэргэжлийн ёс зүй” сэдвээр Анагаах ухааны доктор, профессор, МУ-ын Хүний гавъяат эмч, АШУҮИС-ийн профессор багш С.Сээсрэгдорж 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд (сувилагч, эм зүйч, эм найруулагч, техникч, лаборант, хөдөлгөөн засалч, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд г.м)-д сургалт хийсэн. Сургалтанд 313 ажилтан хамрагдсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 13-нд зохион байгуулсан. өрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан
--	---	--------------------	--	---

					<p>сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 зэрэг бодлогын баримт бичгүүдийг танилцуулах, хүн хоорондын харилцааны ёс зүйн сэдвээрх сургалтыг ХСҮТ-ийн хүсэлтээр Монгол улсын ёс зүйн хорооны гишүүн, АШУҮИС-ийн багш, доктор, дэд профессор М.Цэрэнбат чиглүүлэн зааж, уг сургалтад тус төвийн 308 эмч, ажилтан хамрагдлаа.</p> <p>– Төлөвлөгөөний дагуу 2024 оны 10-р сард нийт 231 эмч, мэргэжилтнүүдийг хамруулан зөвхөн тохиолдол бүхий асуумжаар үнэлгээ хийсэн.</p> <p>Судалгаагаар эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн тухай ойлголт, хандлага, дадлыг дүрмийн асуулт, асуумжаар авдаг арга барилыг шинэчлэх, мөрдөх ёстой дүрмийг бүтнээр нь биш хэсэгчлэн сонгож илүү тодорхой, нарийвчилсан мэдээлэл авахыг зорьсон.</p> <p>Энэ удаад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн “Хувь хүнийг хүндэтгэн үзэх зарчим”-ыг сонгон эмнэлгийн ажилчдын уг зарчмын талаарх мэдлэг, хандлагын түвшинг тохиолдолд суурилсан асуумжаар үнэлгээ хийсэн. Уг асуумжийн дүгнэлтээс үндэслэн хийх ажлуудаа 2025 онд зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн “Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн эрсдэлийг тохиолдолд суурилсан асуумжаар үнэлсэн нь” гэсэн эрдэм шинжилгээний ажил болгон ёс зүйн асуудлууд эрдэм шинжилгээний хуралд материалаа хүргүүлсэн.</p> <p>– Тус төвийн амбулаторийн тасгийн цахим бүртгэгч, хөтөч нарт зориулсан “Ажилтан бүр хөтөч”, “Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй” сэдэвт сургалтыг 11-р сард зохион байгуулсан.</p> <p>– Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй сургалтад цахим бүртгэгч, хөтөч нар хамрагдсанаас гадна хорт хавдрыг даван туулж буй 2 даван туулагч мөн уг сургалтад хамрагдсан.</p> <p>Уг сургалтандаа оролцооны арга зүйд суурилсан танхимын сургалтын хэлбэрийг ашигласан бөгөөд сургалтын ихэнх цаг хугацаанд оролцогчдыг баг болгон ажиллуулах, тэдний мэдлэг чадварыг бататгах байдлаар явсан нь оролцогчдын хувьд илүү сонирхолтой өөрсдийнхөө хувьд шинийг мэдсэн,</p>
--	--	--	--	--	--

					<p>баг хамт олон болж ажилласан, бусдаасаа суралцсан гэх мэтчилэн олон олон давуу талтай байлаа.</p> <p>Сургалт эхлэхийн өмнө болон дууссаны дараа сургалтад оролцогчдын мэдлэг сорих сорилыг авч сургалтын үнэлгээг хийж, сургалт хэр үр дүнтэй явагдаж буйг дүгнэсэн юм.</p> <p>– 2024 онд ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тасаг, албадын дунд Нөхөрсөг уулзалтыг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу эхний уулзалтыг Туяа эмчилгээний тасаг, Хорт хавдрын бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны ажилтнуудын дунд хийсэн. 2 дахь уулзалтыг Хагалгаа, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг, Халдварын сэргийлэлт, хяналтын албаны ажилтнуудын дунд тус тус зохион байгуулсан. Уулзалтаар ажилтнууд хоорондоо илүү сайн танилцах, өөрсдийн мэргэжил, хэрэгжүүлдэг үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл солилцох, цаашид олон мэргэжилтний багийн ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, хамт олны дундах эерэг уур амьсгалыг дэмжих зорилготойгоор амжилттай зохион байгуулав.</p> <p>Хавсралт-3. Ёс зүйн салбар хорооны ажлын тайлан</p>
--	--	--	--	--	---

Тайлан хянасан:

Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал

Нийгмийн эрүүл мэнд, сургалтын албаны дарга

Ц.Уранчимэг

Ц.Бадамсүрэн

Тайлан нэгтгэсэн:

Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн

А.Цэнд-Өлзий

“МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Хүрсэн түвшин (2023 оны жилийн эцэс)	Тайлагнах байгууллага	Тайлбар
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО					
2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжиг сайжруулна.					
1	Хорт хавдрын эрт илрүүлгийн хувь	хувь	34.6%	ХСҮТ	2023 оны хорт хавдрын өвчлөлийн жилийн эцсийн тайлангаар хорт хавдрын (in situ-TNM II stage) 34.6 хувь эрт үедээ оношлогдсон байна.
2	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	37.8 %	ХСҮТ	УХХХ эрт илрүүлгийн хамрагдалтын хувь 2023 оны жилийн эцсийн тайлангаар 37.8 хувьтай гарсан байна. 2024 оны эхний 5 сарын байдлаар хамрагдалтын хувь 18.9 байна.

Тайлан хянасан:

Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал

Ц.Уранчимэг

Нийгмийн эрүүл мэнд, сургалтын албаны дарга

Ц.Бадамсүрэн

Тайлан нэгтгэсэн:

Хяналт шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн

А.Цэнд-Өлзий